



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

Цагаан Эрэг II баг

Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040

E-mail: Selenge@audit.gov.mn

“ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
ДУНДЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН
ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б. МӨНХТӨР ТАНАА

2022.03.25 № СЗА-2022/16-НА-СТА-ОНА

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу “Тариалан эрхлэлтийг дэмжих дундын техникийн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгуудад аудит хийхээр байсан.

“Тариалан эрхлэлтийг дэмжих дундын техникийн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулгад дүгнэлт өгөхгүй.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд аудитын дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо авах боломжгүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

- Тариалан эрхлэлтийг дэмжих дундын техникийн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ нь 2013 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй, дарга Б.Мөнхтөрийг уг үүрэгт ажлаас нь чөлөөлөлгүйгээр 2016 онд аймгийн ХХААГ-ын даргаар томилсноос үйлдвэрийн газрын удирдлага тодорхой бус бөгөөд тус аж ахуйн нэгжийн хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн хөрөнгүүдийн хөдлөл, өөрчлөлтийг шийдвэрлээгүй гэх үндэслэлээр татан буулгаагүй, 2021 оны санхүүгийн тайлан гаргаагүй.
- Өмнөх онуудын / 2019, 2020 онууд / санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд тусгагдсан 61,399.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь бодитоор оршин байхгүй, ХХААХҮЯ-ны ТЭДС-аас 2009 оны 100 дугаар санхүүгийн гэрээгээр хүлээн авсан 1,855,618.8 мянган төгрөгийн өртөг бүхий 28 ширхэг техник, тоног төхөөрөмжөөс 291,434.6 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн аваагүй гэх үндэслэлээр санхүүгийн тайланд тусгагдаагүй учир дутагдсан хөрөнгүүдийн

СЗА-2022/ 16-НА-СТА-ОНА

018020399

хөдлөл өөрчлөлт, шалтгааныг тогтоох албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлээгүй.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.17, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтууд болон санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА